



"УЛСЫН ИХ ДЭЛГҮҮР" ХК ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2019 оны 03 дугаар
сарын 18-ны өдөр


Дугаар 04

Улаанбаатар
хот

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит
хурлыг зарлан хуралдуулах тухай

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2019 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн хуралдаанаар хэлэлцээд **ТОГТООХ** нь:

1. Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2019 оны 04 дүгээр сарын 29-ний даваа гарагт 10.00 цагт Сүхбаатар дүүрэг 100 айлын уулзварын баруун хойно байрлах хэвлэлийн хүрээлэнгийн зүүн талд байрлах Барилгын дэвшилтэт технологийн төвийн 6 давхрын хурлын танхимд хуралдуулахаар тогтоосугай.
2. Хувьцаа эзэмшигчдийн хурлаар дараах асуудлуудыг хэлэлцүүлэхээр баталсугай. Үүнд:
 1. Компанийн 2018 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэн батлах,
 2. Компанийн 2018 оны аудитаар баталгаажсан санхүүгийн тайлан тэнцэл, түүнд хийсэн ТУЗ-ийн Аудитын хорооны дүгнэлтийг хэлэлцэж батлах,
 3. Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн 2019 оны зардлын төсвийг батлах,
3. Компани нь сүүлийн жилүүдэд бий болсон хуримтлагдсан алдагдлаа нөхөж чадаагүй болон болон 2018 онд алдагдалтай ажилласныг харгалзан 2018 оны тайлант жилийн үйл ажиллагааны орлогоос ногдол ашиг хуваарилахгүй байхаар шийдвэрлэснийг хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулсугай.
4. Монголын хөрөнгийн биржийн цахим хуудсаар дамжуулан 2019 оны 03 дугаар сарын 21-ний өдөр хурлын зарыг нийтэд эхэлж хүргэхээр тогтоосугай.
5. Хувьцаа эзэмшигчдийн хурлын зарыг 2019 оны 03 дугаар сарын 21-ний өдөр, 2019 оны 04 дүгээр сарын 05-ны өдрүүдэд Засгийн газрын мэдээ, Үндэсний шуудан гэсэн өдөр тутмын сонинууд, TV9, UBS телевизүүдээр хувьцаа эзэмшигчдэд хүргэхээр тогтоосугай.
6. Хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2019 оны 04 дүгээр сарын 08-ны өдрөөр тасалбар болгосугай.
7. Хувьцаа эзэмшигчдийн хурлын материалыг "Хавсралт 1"-ээр баталсугай.
8. Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх хурлын материал, санхүүгийн тайлан, аудиторын дүгнэлт болон бусад бичиг баримт, шийдвэрийн төсөлтэй хувьцаа эзэмшигчид ХУД-ийн 2-р хороо, Чингисийн өргөн чөлөө, 67/1 хаягт буюу Номин Юнайтед цогцолборын 5-р давхарт ТУЗ-ийн нарийн бичгийн дарга дээр Даваа-Баасан гаригуудад ажлын цагаар танилцах боломжтой болохыг мэдээлсүгэй.
9. Хувьцаа эзэмшигчдийн хурлын санал авах хуудсыг "Хавсралт 2"-оор баталсугай.
10. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын материалыг Монголын хөрөнгийн биржээр дамжуулан тараах, санал авах болон хурал зохион байгуулах үйл ажиллагааг үнэт цаасны зах зээлийн мэргэжлийн байгууллага болох "Дэлгэрхангай Секьюритис" брокер дилерийн компаниас зөвлөгөө авч хамтран ажиллахыг зөвшөөрсүгэй.
11. Хувьцаа эзэмшигчдийн хуралд биечлэн оролцох боломжгүй хувьцаа эзэмшигчдээс саналын хуудсаар санал авах сүүлчийн хугацааг 2019 оны 04 дүгээр сарын 23-ны өдрөөр тасалбар болгож, "Дэлгэрхангай Секьюритис" брокер дилерийн компани болон ХУД-ийн 2-р хороо Чингисийн өргөн чөлөө, 67/1 хаягт буюу Номин Юнайтед цогцолборын 5-р давхарт тус тус хүлээж авахаар тогтоосугай.
12. Хувьцаа эзэмшигчдийн хурлын даргаар Гүйцэтгэх захирал С.Сайнбатыг томилсугай.
13. Хувьцаа эзэмшигчдийн хурлын тооллогын комиссын дарга, гишүүдийг хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцогсдоос томилохоор тогтсугай.
14. Хурал зохион байгуулах комиссын даргаар Гүйцэтгэх захирал С.Сайнбатыг, гишүүдээр Төлөөлөн удирдан зөвлөлийн даргаар В.Хуучинбалхад, ахлах нягтлан бодогч Д.Чимгээ нарыг томилсугай.



С.ХОСБАЯР